



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2015 оны 9 сарын 10 өдөр

Дугаар А-126

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 194 дүгээр тушаалаар батлагдсан “Монголбанкны үйл ажиллагаатай олон нийтийг танилцуулах журам”-д дор дурдсан хэсгийг нэмсүгэй:

2.1.8. “Мөнгө, ханшийн бодлого”

2. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 194 дүгээр тушаалаар батлагдсан “Монголбанкны үйл ажиллагаатай олон нийтийг танилцуулах журам”-д дор дурдсан заалтын дараах хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

“4.3. Танилцуулах ажиллагааг хүсэлт ирүүлсэн байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр олон нийтэд нээлттэй бөгөөд ажлын өдрүүдэд 1 цагийн хугацаатайгаар зохион байгуулна.”

“4.4. Нэг удаагийн танилцуулах үйл ажиллагаанд 40-өөс дээшгүй хүн хамрагдана. Шаардлагатай тохиолдолд Монголбанкны Аюулгүйн албанаас зөвшөөрөл авсны үндсэн дээр хамрагдах хүний тоог нэмэгдүүлж болно.”

“6.1. “Монголбанкны үйл ажиллагаатай танилцах танилцуулгад оролцогчид нь иргэд, байгууллагын төлөөлөл, их дээд болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагсад, сэтгүүлчид (хүсэлт гаргасан хүмүүс хамрагдах боломжтой) байна.”

3. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 194 дүгээр тушаалаар батлагдсан “Монголбанкны үйл ажиллагаатай олон нийтийг танилцуулах журам”-д дор дурдсан заалтыг заалтыг өөрчилсүгэй.

3.1.1 дэх заалтын “Төлбөр тооцоо бүртгэлийн газар, Хяналт шалгалтын газар, Хуулийн хэлтэс, Мөнгөний бодлого судалгааны газар, Валют эдийн засгийн газар, Мөнгөн тэмдэгтийн хэлтэс” гэснийг “ОНБМТ-ийн боловсролын албаны мэргэжилтэн” гэж, 5.1 дэх хэсгийн “...Монголбанкны хэвлэл мэдээллийн ажилтан байна.” гэснийг “...ОНБМТ-ийн мэргэжилтэн байна.” гэж, 6.2 дахь хэсгийн “...Олон нийттэй харилцах хэлтэс...” гэснийг “...Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв...” гэж, 2.1.4, 2.1.5 дахь заалтыг нэгтгэж “...Банк хоорондын төлбөр тооцоо, эмиссийн үйл ажиллагаа...” гэж, 2.1.6, 2.1.7 дахь заалтын дугаарлалтыг 2.1.5, 2.1.6 гэж.

141220

4.Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг Тамгын газар (Д.Чимэд-Юндэн), Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв (Ю.Гэрэлтуяа)-д тус тус үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-г тус тус даалгасугай.



ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЗОЛЖАРГАЛ

МОНГОЛБАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ОЛОН

НИЙТИЙГ ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ

- НЭГ. Нийтлэг үндэслэл
- ХОЁР. Танилцуулах сэдэв, агуулга
- ГУРАВ. Танилцуулах ажиллагааны хөтөлбөр
- ДӨРӨВ. Танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх зарчим
- ТАВ. Танилцуулга хийх хөтөлгөчийн үүрэг
- ЗУРГАА. Танилцуулгад оролцогчид
- ДОЛОО. Бусад зүйл

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. “Төв банк /Монголбанк/-ны тухай” хуулийн хүрээнд Монголбанкны бодлого, үйл ажиллагааг олон нийтэд танилцуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

ХОЁР. Танилцуулах сэдэв, агуулга

2.1. Монголбанкны үндсэн зорилт, үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний мөн чанарыг олон нийтэд танилцуулна:

2.1.1. “Төв банк /Монголбанк/-ны тухай” хуульд заасан Монголбанкны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс

2.1.2 Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банкны салбарын тогтвортой байдлыг хангах үүднээс Монголбанкнаас явуулж байгаа арга хэмжээ

2.1.3 Монголбанкны газар хэлтсүүдийн чиг үүрэг

2.1.4 Банк хоорондын төлбөр тооцоо, эмиссийн үйл ажиллагаа

[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

2.1.5 Банкны үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

2.1.6 Улсын гадаад валютын нөөцийн удирдлага

2.1.7 Мөнгө, ханшийн бодлого

[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар хассан.](#)

ГУРАВ. Танилцуулах ажиллагааны хөтөлбөр

3.1. Монголбанкны үйл ажиллагааг дараах хөтөлбөрийн дагуу танилцуулна.

3.1.1. Монголбанкны зорилт, статус, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийн талаар хөтөлгөч ерөнхий танилцуулга хийх

- 1. Банк хоорондын төлбөр тооцоо хэрхэн явагддаг талаар танилцуулах
- Банк хоорондын төлбөр хийгддэг зарчим

/ОНБМТ-ийн Боловсролын албаны мэргэжилтэн -5 минут/

[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

- 2. Банкны хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар танилцуулах
 - Хяналт шалгалтын зорилго, үндсэн зарчим
 - Зайнаас хийгдэх хяналт шалгалт
 - Газар дээр нь хийх шалгалт

/ОНБМТ- ийн Боловсролын албаны мэргэжилтэн- 5 минут /
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

- 3. Банкны хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийх
 - “Төв банк /Монголбанк/-ны тухай” хууль
 - “Банкны тухай” хуулийг танилцуулах

/ОНБМТ- ийн Боловсролын албаны мэргэжилтэн- 5 минут /
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

- 4. Мөнгөний болон банкны салбарын статистик судалгаа, ач холбогдлыг танилцуулах
 - Статистик судалгааны зорилго, ач холбогдол

/ОНБМТ- ийн Боловсролын албаны мэргэжилтэн- 5 минут /
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

- 5. Улсын валютын нөөцийг эзэмшиж зохицуулах болон валютын ханшийн бодлого, банк хоорондын захын арилжааны талаар танилцуулах
 - Улсын валютын нөөцийн удирдлага, зохицуулалт
 - Банк хоорондын зах, валютын арилжаа, ханш
 - Олон улсын санхүүгийн байгууллагуудтай харилцах харилцаа

/ОНБМТ- ийн Боловсролын албаны мэргэжилтэн- 5 минут /
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

- 6. Мөнгөний бодлого, түүний хэрэгжилт, мөнгөний бодлогын хэрэгслүүд инфляцийн түвшингийн талаар мэдээлэл хийх
 - Төв банкны үнэт цаас, түүний арилжаа
 - Заавал байлгах нөөц
 - Инфляцийн түвшин

/ОНБМТ- ийн Боловсролын албаны мэргэжилтэн- 5 минут /
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

- 7. Эмиссийн үйл ажиллагаа, эрдэнэсийн сангийн талаар танилцуулах
 - Мөнгөн тэмдэгтийн нууц хийцүүд
 - Хуучирч муудсан ба хүчингүй мөнгөн тэмдэгтийн тухай
 - Мөнгөн тэмдэгтийн устгал

/ОНБМТ- ийн Боловсролын албаны мэргэжилтэн- 5 минут /
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

ДӨРӨВ. Танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх зарчим

Танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулахдаа дараахь зарчмыг мөрдлөг болгоно.

4.1. Танилцуулах үйл ажиллагааны хүрээнд Монголбанкны тусгай өрөө тасалгаа /мөнгө тоолох өрөө, касс, бэлтгэл сангийн болон эрдэнэсийн сангийн агуулах/-нд нэвтрэхийг хориглоно.

4.2. Танилцуулах үйл ажиллагааны явцад нууцын заавар, нууцын жагсаалт, зэрэглэлд хамрагдах мэдээллийн нууцлалыг чанд хадгална.

4.3. **Танилцуулах ажиллагааг хүсэлт ирүүлсэн байгууллага, сургуультай тохиролцсоны үндсэн дээр олон нийтэд нээлттэй бөгөөд ажлын өдрүүдэд 1 цагийн хугацаатайгаар зохион байгуулна.**
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

4.4. **Нэг удаагийн танилцуулах үйл ажиллагаанд 40-өөс дээшгүй хүн хамрагдана. Шаардлагатай тохиолдолд Монголбанкны Аюулгүйн албанаас зөвшөөрөл авсны үндсэн дээр хамрагдах хүний тоог нэмэгдүүлж болно.**
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

4.5. Танилцуулах үйл ажиллагааг оролцогчдоос урьдчилан авсан санал асуулгад үндэслэн тодорхой сэдвээр дэлгэрэнгүй байдлаар зохион байгуулж болно.

4.6. Санал асуулга явуулах ажлыг Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв зохион байгуулах бөгөөд оролцогчдоос гаргасан сэдвээр зохион байгуулах дэлгэрэнгүй танилцуулгын сэдвийн талаар хөтлөгчид урьдчилан захиалга өгнө.

4.7. Тодорхой сэдвээр явуулах танилцуулгад дэлгэрэнгүй материал, ном, брошур, дэлгэцийн үзүүлэн /power point/ зэргийг ашиглана.

ТАВ. Танилцуулга хийх хөтлөгчийн үүрэг

Танилцуулгыг Монголбанкны хөтлөгч удирдаж зохион байгуулна.

5.1. Хөтлөгч нь Монголбанкны **ОНБМТ-ийн мэргэжилтэн** байна.
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

5.2. Хөтлөгч нь Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвд ирүүлсэн албан ёсны хүсэлтийг үндэслэн танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулах хуваарийг ОНБМТ-ийн захиралд танилцуулж Монголбанкны Аюулгүйн албанаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зохион байгуулна.

5.3. Хөтлөгч нь танилцуулгад оролцогчдын албан ёсны хүсэлт, нэрсийн жагсаалтыг Банкны хамгаалалтын ажилтанд урьдчилан гарган өгч, бичиг баримтыг сайтар шалгуулсны үндсэн дээр Монголбанкинд нэвтрүүлнэ.

5.4. Хөтлөгч нь танилцуулгад оролцогчдыг Монголбанкинд нэвтрүүлэхээс эхлэн танилцуулгын төгсгөлд үдэж гаргах хүртэл хугацаанд Монголбанкны дотоод журамд заагдсан асуудлыг бүрэн хариуцна.

5.5. Хөтлөгч нь энэхүү журамд заасан сэдэв, хөтөлбөрийн хүрээнд танилцуулгыг зохион байгуулна.

5.6. Хөтлөгч нь удирдлагын болон газар, хэлтсийн захирлын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн өөрийн байр сууринаас аливаа мэдээлэл хийхийг хориглоно.

ЗУРГАА. Танилцуулгад оролцогчид

6.1. Монголбанкны үйл ажиллагаатай танилцах танилцуулгад оролцогчид нь иргэд, байгууллагын төлөөлөл, их дээд болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагсад, сэтгүүлчид (хүсэлт гаргасан хүмүүс хамрагдах боломжтой) байна.

[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

6.2. Танилцуулгад оролцогчид нь танилцуулгад оролцох албан ёсны хүсэлтээ өөрийн байгууллага, сургуулиар дамжуулан **Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвд** гаргана.

[МБЕ-ийн 2015.09.10-ны А-126 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

6.3. Танилцуулгад оролцогчид нь ажлын газрын /иргэний үнэмлэх/ болон оюутны үнэмлэхийг хамгаалалтын ажилтанд заавал шалгуулна.

6.4. Танилцуулгад оролцогч нь Монголбанкны үйл ажиллагаатай танилцах явцдаа Монголбанкны дотоод журмыг чанд сахиж, хөтлөгчийн заасан чиглэлийн хүрээнд танилцуулгад хамрагдана.

ДОЛОО. Бусад зүйл

7.1. Танилцуулгад оролцогчдод Монголбанкны хаяг, утас, интернэт дэх веб сайтын хаяг болон сонирхсон зарим мэдээллийг /нууцын бус/ хэвлэл мэдээллийн албаны мэдээллийн сан болон лавлагаанаас гарын авлага, материал маягаар гаргаж өгч болно.

МОНГОЛБАНК